МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

# 2018 7-Р САР

# Э-сонин

60-р дугаар



# Үнэт цаасны зах зээл

## Зах зээлийн тойм

/2018.07.31-ний өдрийн байдлаар/

| | |
|---|---|
| **1. Арилжаа явагдсан өдөр** | **19** |
| **2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/** | **4,315,707,064.95** |
| *Хувьцаа /анхдагч/* | 0 |
| *Хувьцаа /хоёрдогч/* | 3,135,829,814.95 |
| *Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/* | 1,179,877,250.00 |
| *Компанийн бонд /анхдагч/* | 0 |
| *Компанийн бонд /хоёрдогч/* | 0 |
| **3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг** | **18,187,107** |
| *Хувьцаа /анхдагч/* | 0 |
| *Хувьцаа /хоёрдогч/* | 18,175,937 |
| *Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/* | 11,170 |
| *Компанийн бонд /анхдагч/* | 0 |
| *Компанийн бонд /хоёрдогч/* | 0 |
| **4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо** | **2,767** |

## Зах зээлийн үнэлгээ




## TOP-20 индекс




## MSE A индекс




/Нэгж/

## MSE B индекс




/Нэгж/

## Бүртгэлтэй хувьцаат компани

| | |
|---|---|
| **1.Нийт компанийн тоо** | **220** |
| *100% төрийн өмчит* | 19 |
| *Төрийн өмчийн оролцоотой* | 12 |
| *Хувийн өмчийн* | 189 |
| *I ангилал* | 9 |
| *II ангилал* | 42 |
| *III ангилал* | 169 |

## Гишүүн үнэт цаасны компани

| | | |
|---|---|---|
| **1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо** | | **59** |
| *Үүнээс:* | *Брокер, Дилер* | 50 |
| | *Андеррайтер* | 23 |
| | *Хөрөнгө оруулалтын зөвлөх* | 13 |

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны гишүүн компаниуд

/2018.07.31-ний байдлаар/

| Симбол | Нэр | Үнэт цаас авсан | | Үнэт цаас зарсан | | Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮) |
|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Үнийн дүн (₮) | Тоо ширхэг | Үнийн дүн (₮) | |
| 1 | БиДиСек ХК | 6,206,494.00 | 1,203,041,461.16 | 5,900,721.00 | 1,163,750,608.08 | 2,366,792,069.24 |
| 2 | Ард секюритиз ХХК | 903,974 | 407,148,668.43 | 556,723 | 337,924,185.25 | 745,072,853.68 |
| 3 | Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК | 5,376,472.00 | 361,549,964.91 | 5,582,141.00 | 372,842,747.66 | 734,392,712.57 |
| 4 | Голомт Капитал ХХК | 1,953,542 | 371,653,081.18 | 1,114,614 | 168,854,464.43 | 540,507,545.61 |
| 5 | Ти Ди Би Капитал ХХК | 867,023 | 178,936,142.01 | 1,259,030 | 186,577,890.68 | 365,514,032.69 |
| 6 | Бумбат-Алтай ХХК | 849,103 | 125,925,754.99 | 691,881 | 187,047,421.89 | 312,973,176.88 |
| 7 | Гаули ХХК | 896,138 | 172,009,371.52 | 383,636 | 123,954,744.81 | 295,964,116.33 |
| 8 | Стандарт инвестмент ХХК | 192,327 | 90,081,537.47 | 1,233,069 | 121,640,755.08 | 211,722,292.55 |
| 9 | Новел инвестмент ХХК | 328,696 | 61,607,897.86 | 631,710 | 90,321,703.31 | 151,929,601.17 |
| 10 | Апекс капитал | 54,467.00 | 7,971,855.26 | 3,375.00 | 63,722,364.43 | 81,694,219.69 |
| 11 | Ард капитал групп ХХК | 65,912 | 12,296,867.28 | 158,807 | 67,925,046.56 | 80,221,913.84 |
| 12 | Азиа Пасифик секьюритис ХХК | 0 | 0.00 | 162,950 | 71,120,900.00 | 71,120,900.00 |
| 13 | Хүннү Эмпайр ХХК | 40,428 | 30,071,760.00 | 69,749 | 14,436,492.00 | 44,508,252.00 |
| 14 | Зэргэд ХХК | 193,583 | 32,207,355.58 | 10,316 | 4,070,692.20 | 36,278,047.78 |
| 15 | Монсек ХХК | 49,932 | 12,582,902.20 | 42,053 | 22,088,650.20 | 34,671,552.40 |
| 16 | Таван богд ХХК | 0 | 0.00 | 18,586 | 33,574,910.00 | 33,574,910.00 |
| 17 | Блүмсбюри секюритиес ХХК | 36,187 | 14,512,505.50 | 7,916 | 11,794,840.00 | 26,307,345.50 |
| 18 | Гендекс ХХК | 4,382 | 15,823,620.00 | 16,266 | 9,539,290.00 | 25,362,910.00 |
| 19 | Санар ХХК | 9,366 | 2,054,444.00 | 23,707 | 15,579,372.00 | 17,633,816.00 |
| 20 | Евразиа капитал монголиа ХХК | 40,210 | 6,152,201.60 | 20,469 | 7,924,361.60 | 14,076,563.20 |

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.07.31-ний байдлаар/

| № | Сим-бол | Үнэт цаасны нэр | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /₮/ | Дээд Ханш | Доод Ханш | Өөрчлөлт /Нэгж/ | Өөрчлөлт /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MIB | МОНИНЖБАР | 5,150,001 | 875,500,195.50 | 195.50 | 170.00 | 45.50 | 30.33 |
| 2 | LEND | ЛЭНДМН ББСБ ХК | 10,454,682 | 664,024,480.58 | 75.00 | 56.00 | 16.80 | 29.79 |
| 3 | APU | АПУ | 536,997 | 317,983,268.36 | 634.00 | 570.00 | -31.72 | -5.01 |
| 4 | MNP | МОНГОЛ ШУУДАН ХК | 515,931 | 299,495,783.00 | 600.00 | 570.00 | 5.54 | 0.96 |
| 5 | MBW | МОНГОЛ БАЗАЛЬТ ХК | 534,295 | 203,979,631.24 | 409.00 | 350.00 | -32.64 | -8.06 |
| 6 | TTL | ТАВАН ТОЛГОЙ | 21,918 | 198,989,370.00 | 9,800.00 | 8,310.00 | -1,215.00 | -12.58 |
| 7 | ERDN | ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ | 219,826 | 140,694,952.96 | 656.00 | 561.00 | -51.00 | -7.85 |
| 8 | GOV | ГОВЬ | 4,700 | 113,787,820.00 | 25,900.00 | 23,800.00 | 980.00 | 4.08 |
| 9 | BDS | БИ ДИ СЕК | 89,351 | 89,179,829.00 | 1,145.00 | 960.00 | -50.00 | -4.76 |
| 10 | JIV | ЖИНСТ-УВС | 47,143 | 69,789,710.00 | 1,546.00 | 1,400.00 | 54.00 | 3.62 |
| 11 | SUU | СҮҮ | 143,899 | 31,043,723.00 | 220.00 | 205.10 | 1.67 | 0.78 |
| 12 | SUL | ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ | 253 | 22,549,280.00 | 96,080.00 | 86,000.00 | 0.00 | 0.00 |
| 13 | ITLS | АЙТҮҮЛС | 139,493 | 18,219,267.30 | 134.00 | 128.00 | 0.00 | 0.00 |
| 14 | HRM | ГЕРМЕС ЦЕНТР | 71,523 | 10,379,550.00 | 150.00 | 145.00 | 4.32 | 2.97 |
| 15 | NEH | ДАРХАН НЭХИЙ | 388 | 7,621,820.00 | 20,500.00 | 18,060.00 | -1,500.00 | -7.32 |
| 16 | BNG | БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ | 254 | 7,620,000.00 | 30,000.00 | 30,000.00 | 0.00 | 0.00 |
| 17 | MIE | МАТЕРИАЛИМПЕКС | 743 | 6,932,490.00 | 9,490.00 | 9,000.00 | 0.00 | 0.00 |
| 18 | MMX | МАХИМПЕКС | 2,386 | 6,570,535.00 | 3,000.00 | 2,505.00 | -199.00 | -7.11 |
| 19 | TCK | ТАЛХ ЧИХЭР | 292 | 6,351,700.00 | 22,000.00 | 21,000.00 | -1,000.00 | -4.44 |
| 20 | SHG | ШАРЫН ГОЛ | 2,867 | 5,937,280.00 | 2,250.00 | 2,000.00 | -150.00 | -6.67 |

## Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.07.31-ний байдлаар/

| № | Үнэт цаас нэр | Арилжигдсан /Ширхэг/ | Хаалтын ханш | | Ханшийн өөрчлөлт /₮/ | Өөрчлөлт /%/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2018-07-01 | 2018-07-31 | | |
| 1 | БАЯЛАГ НАЛАЙХ | 270 | 311.00 | 410.50 | 99.50 | 31.99 |
| 2 | МОНИНЖБАР | 5,150,001 | 150.00 | 195.50 | 45.50 | 30.33 |
| 3 | ЛЭНДМН ББСБ ХК | 10,454,682 | 56.40 | 73.20 | 16.80 | 29.79 |
| 4 | БИНСЭ ХК | 1 | 350.00 | 400.00 | 50.00 | 14.29 |
| 5 | ГУТАЛ | 20 | 19,500.00 | 22,000.00 | 2,500.00 | 12.82 |
| 6 | ХҮННҮ МЕНЕЖМЕНТ | 1,582 | 164.05 | 185.00 | 20.95 | 12.77 |
| 7 | УСЖУУЛАХ | 305 | 533.39 | 600.00 | 66.61 | 12.49 |
| 8 | МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО | 4,382 | 480.00 | 510.00 | 30.00 | 6.25 |
| 9 | ГОВЬ | 4,700 | 24,020.00 | 25,000.00 | 980.00 | 4.08 |
| 10 | ЖИНСТ-УВС | 47,143 | 1,490.00 | 1,544.00 | 54.00 | 3.62 |
| 11 | ГЕРМЕС ЦЕНТР | 71,523 | 145.68 | 150.00 | 4.32 | 2.97 |
| 12 | ХӨХ ГАН | 26,616 | 95.00 | 96.00 | 1.00 | 1.05 |
| 13 | НАКО ТҮЛШ | 301 | 148.52 | 150.00 | 1.48 | 1.00 |
| 14 | МОНГОЛ ШУУДАН ХК | 515,931 | 578.26 | 583.80 | 5.54 | 0.96 |
| 15 | СҮҮ | 143,899 | 215.00 | 216.67 | 1.67 | 0.78 |
| 16 | ШИВЭЭ ОВОО | 98 | 2,050.00 | 2,060.00 | 10.00 | 0.49 |
| 17 | ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ | 253 | 90,000.00 | 90,000.00 | 0.00 | 0.00 |
| 18 | АЙТҮҮЛС | 139,493 | 130.00 | 130.00 | 0.00 | 0.00 |
| 19 | БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ | 254 | 30,000.00 | 30,000.00 | 0.00 | 0.00 |
| 20 | МАТЕРИАЛИМПЕКС | 743 | 9,000.00 | 9,000.00 | 0.00 | 0.00 |

## Ханшийн бууралттай хувьцаа

/2018.07.31-ний байдлаар/

| № | Үнэт цаас нэр | Арилжигдсан / Ширхэг/ | Хаалтын ханш (₮) | | Ханшийн өөрчлөлт (₮) | Өөрчлөлт % |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2018-07-01 | 2018-07-31 | | |
| 1 | УВС ЧАЦАРГАНА | 26 | 980.00 | 675.00 | -305.00 | -31.12 |
| 2 | ХИШИГ УУЛ | 183 | 949.32 | 700.00 | -249.32 | -26.26 |
| 3 | СИЛИКАТ | 45 | 200.00 | 150.00 | -50.00 | -25.00 |
| 4 | ОЛЛОО | 3,000 | 60.01 | 51.01 | -9.00 | -15.00 |
| 5 | ЭРДЭНЭТ АВТО ЗАМ | 1 | 985.00 | 840.00 | -145.00 | -14.72 |
| 6 | МОНГОЛ СЕКЮРИТИЕС | 165 | 470.00 | 403.03 | -66.97 | -14.25 |
| 7 | БӨХӨГ | 25 | 3,450.00 | 3,000.00 | -450.00 | -13.04 |
| 8 | УБ-БҮК | 4,001 | 425.00 | 371.00 | -54.00 | -12.71 |
| 9 | БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК | 1 | 469.48 | 410.00 | -59.48 | -12.67 |
| 10 | ТАВАН ТОЛГОЙ | 21,918 | 9,655.00 | 8,440.00 | -1,215.00 | -12.58 |
| 11 | ХАРХОРИН | 43 | 1,600.00 | 1,400.00 | -200.00 | -12.50 |
| 12 | ХАЙ БИ ОЙЛ | 34,385 | 62.50 | 55.00 | -7.50 | -12.00 |
| 13 | МОНГОЛ ШИЛТГЭЭН | 101 | 544.00 | 478.90 | -65.10 | -11.97 |
| 14 | АТАР-ӨРГӨӨ | 55 | 69,900.00 | 61,900.00 | -8,000.00 | -11.44 |
| 15 | НОЁТ ХАЙРХАН | 1 | 1,125.00 | 1,000.00 | -125.00 | -11.11 |

## "ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК НЭМЖ ҮНЭТ ЦААС ГАРГАХААР БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 06 сарын 29-ний өдрийн 262 тоот тогтоолоор "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн нэмж гаргаж байгаа нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4,405,600 ширхэг хувьцааг бүртгэж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулламаа.

Нэмж гаргасан хувьцааны 3,328,600 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар стратегийн хөрөнгө оруулагч нарт нэг бүрийг нь 850 төгрөгөөр, 1,177,000 ширхэг хувьцааг олон нийтэд захиалга бүртгэлийн аргаар санал болгох бөгөөд доод үнийг 850 төгрөгөөр тогтоож анхдагч зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн байна.

## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ

Монгол Улсын Засгийн Газар нь 2018 оны 04 дүгээр сарын 19-ны өдрөөс "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа эзэмшигч болсон тул “Компанийн тухай” хуулийн 57.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 22.1.2 болон СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-ыг үндэслэн үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 94.67 хувь буюу 24,491,390 ширхэгээс бусад хэсгийг худалдан авах санал гаргаж байна. Үүнд:

**Худалдан авахаар санал гаргасан хувьцааны тоо ширхэг** : 1,378,886 ширхэг

**Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа:** 2018 оны 07-р сарын 09-ны өдөр

**Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа:** 2018 оны 09-р сарын 19-ны өдөр

**Нэгж хувьцааны худалдан авах үнэ:** 542.00 / таван зуун дөчин хоёр төгрөг, тэг мөнгө/

**Хувьцааг худалдан авах төлбөрийг гүйцэтгэх хугацаа:** 2018 оны 09-р сарын 20

**Хувьцааг худалдан авах санал гаргагч:** Монгол Улсын Засгийн газар

Хаяг:13381-Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-16, Засгийн газрын IX байр, Холбогдох утас: (976-62) 263034, Факс: 262350, E-mail: info@pcsp.gov.mn

**"Монголын цахилгаан холбоо" ХК-ийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдах хүсэлтэй бол:**

2018 оны 07 сарын 09-ний өдрөөс 2018 оны 09-р сарын 18-ны өдөр хүртэл ажлын өдрүүдэд 08:30 цагаас 17:00 цагийн хооронд, 2018 оны 09-р сарын 19-ны өдрийн 08:30 цагаас 13:00 цагийн хооронд

доорхи байгууллагад хандана уу.

"Гаули ҮЦК" ХХК Хаяг:Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Оюутны гудамж, Сонор плаза 602 тоот, Холбогдох утас: 70153300, 99045961, E-mail: gauli2008@yahoo.com

## ДАВХАР БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСЫГ ХИЛ ДАМЖУУЛАН АРИЛЖААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ХҮСЭЛТИЙГ СЗХ-НД ХҮРГҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн зах зээлд сүүлийн жилүүдэд гарсан томоохон ахиц дэвшлүүдийн нэг нь үнэт цаасны давхар бүртгэлийн ажиллагааг зохицуулах журмыг СЗХ, МХБ хамтран боловсруулж, хамгийн эхний давхар бүртгэлийн компани болох Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ ресурс девелопмент корпорейшнийг МХБ-д бүртгэсэн явдал билээ. Тус компанийн хувьцаа нь одоогийн байдлаар гадаад, дотоодын захуудын хооронд хөрвөн арилжаалагдах боломжгүй байгаа хэдий ч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд хориглосон заалт байхгүй, журмаар зохицуулан хил дамнуулан арилжих боломж нээлттэй байна. Хувьцааг хил дамнуулан арилжаалах зохицуулалтыг бий болгосноор ханшийн тэнцвэртэй байдлыг хангах, дотоодын зах зээлд нийлүүлэлт нэмэгдэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой тул холбогдох журмыг боловсруулах чиглэлээр зах зээлийн мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах саналыг СЗХ-нд хүргүүллээ.

## МХБ-ИЙН "ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ" ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 2018/07 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Гишүүнчлэлийн журам”-ыг 2018 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо батламжилснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэллээ.

# Мэдээ, мэдээлэл

## ИХ БРИТАНИЙН АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙГ ХАРИУЦСАН САЙД МАРК ФИЙЛД МХБ-Д ЗОЧИЛЛОО

Их Британийн Гадаад Харилцааны Яамны Ази Номхон Далайн Бүс Нутгийг хариуцсан сайд Марк Фийлд 2018 оны 7-р сарын 19-22-ны өдрүүдэд Монгол улсад хийж байгаа айлчлалынхаа хүрээнд өнөөдөр буюу 2018 оны 7-р сарын 20-ны өдөр Монголын хөрөнгийн биржид зочиллоо.

Сайд Марк Фийлдэд МХБ-ийн үйл ажиллагаа, цаашдын зорилгыг танилцуулсан бөгөөд манай улсын хөрөнгийн зах зээл хөгжил дэвшил, үйл явдлаар өрнүүн байгааг сайд онцлон тэмдэглэлээ. Монголын хөрөнгийн зах зээлийг цаашид хөгжүүлэх ажил, олон шинэ санаачлагуудад Их Британийн талаас дэмжин хамтран ажиллах бөгөөд өдгөө долоо дахь жилдээ үргэлжилж буй Монголын хөрөнгийн бирж болон Лондонгийн хөрөнгийн биржийн стратеги хамтын ажиллагаа нь улам өргөжин тэлнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлж, МХБ-ийн хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурав.

## "УУЖИМ ХАНГАЙ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 76 дугаар тогтоолоор "Уужим хангай" ХК-д "Стандарт агрикалчер групп" ХХК-ийг нэгтгэж 13,735,752 ширхэг хувьцаар "Стандарт капитал" ХХК-д бүртгэсэн тул Хорооны улсын байцаагчийн албан шаардлагын дагуу "Уужим хангай" ХК-ийн үнэт цаасны арилжааг 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн нээлээ.

## "MILLENNIUM EXCHANGE" СИСТЕМ АРИЛЖААНЫ ШИЛДЭГ СИСТЕМЭЭР ШАЛГАРЧЭЭ

Их Британийн санхүүгийн зах зээлийн мэдээлэл технологийн тэргүүлэгч сэтгүүлүүдийн нэг "Waters" сэтгүүлээс 16 дахь жилдээ зохион байгуулагдаж буй "Waters Rankings Awards 2018" арга хэмжээний үеэр "Millennium Exchange" системийг "Арилжааны шилдэг систем"-ээр тодруулсан байна.

Энэхүү системийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь Лондонгийн хөрөнгийн бирж групптэй байгуулсан “Ажлын мастер гэрээ”-ний хүрээнд 2012 оноос эхлэн өдөр тутмын арилжаанд хэрэглэж байгаа билээ.

"Миллениум Ай Ти" цогц системийг дэлхийн 10 гаруй улсын 26 хөрөнгийн бирж, банк санхүүгийн байгууллагууд ашиглаж байгаа бөгөөд энэхүү систем нь санхүүгийн бүх төрлийн бүтээгдэхүүнүүдийг төрөл бүрийн аргаар арилжих боломжтой, 50,000 захиалгыг 1 секундэд гүйцэтгэх хүчин чадалтай, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг өндөр түвшинд хангасан, найдвартай ажиллагаатай зэрэг маш олон давуу талтай юм. Түүнчлэн, тус систем нь хөрөнгө оруулагчид онлайнаар арилжаанд оролцох боломжийг олгож байгаа нь үнэт цаасны ханшийн өөрчлөлт секундээр хэмжигдэж, үнэ тогтож байгаа онцлогтой арилжааны хувьд оролцогчдын шударга, жигд оролцоог хангахад хамгийн чухал үзүүлэлт болж байгаа юм.

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖААНД ГАР УТАСНААСАА ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ БОЛНО

"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-аас зах зээлийг идэвхжүүлэх, сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд анхдагч зах зээлийн "IPO систем"-ийн API-ийг хөгжүүлсэн нь анхдагч зах зээлийн захиалгыг илүү хялбараар, хэрэглэгчдэд энгийн байдлаар нэвтрүүлэх боломжийг програм хангамжийн компаниудад олгож байна.

Энэ технологийн боломжийг ашиглан "ECM" ХХК нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах аппликейшныг хөгжүүлсэн бөгөөд мэргэжлийн оролцогч нарт зориулан аппликейшны танилцуулгыг зохион байгууллаа.

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН**

Монгол Улс, Улаанбаатар хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж

+976 11-313747

+976 11-325170

Info@mse.mn

WWW.MSE.MN